"ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 23-ны өдөр

№ 21/43

Улаанбаатар хот

Чанаргүй болон муу активыг зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 144/125 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын 3.6.4 дэх заалт, "ЛэндМН ББСБ" ХК (цаашид "Компани" гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

- Компанийн Гүйцэтгэх удирдлагын саналыг үндэслэн 408,256,984 (дөрвөн зуун найман сая хоёр зуун тавин зургаан мянга есөн зуун наян дөрөв) төгрөгтэй тэнцэх чанаргүй болон муу активыг, тэдгээрт тооцогдсон 17,909,707 (арван долоон сая есөн зуун есөн мянга долоон зуун долоо) төгрөгийн төлөгдөөгүй шимтгэлийн авлагын төлбөрийг Зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах, түүнтэй холбоотой холбогдох нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хийх эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д олгосугай.
- 2. Зээлийн эрсдэлийн сангаас чанаргүй болон муу активыг хорогдуулах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн актууд болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагуудад нийцүүлэн гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Б.Удвал)-д үүрэг болгосугай.

OF DEPENDENCES VOLDE ландмін басб ХК ТУЗ-ИЙН ДАРГА: lendmn УЛААНБААТАР ХОТ 5039754 411/0.БОЛДБААТАР/

"ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 23-ны өдөр

№ 21/44

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Үндсэн хөрөнгө бараа, материалын журмын 6 дугаар зүйлийн 6.3дах заалт, Гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын гэрээний 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

- 1. "ЛэндМН ББСБ" ХК-ийн ашиглалтын шаардлага хангахгүй болсон хавсралтад заасан үндсэн хөрөнгүүдийг актлахыг зөвшөөрсүгэй.
- 2. Хавсралтад тусгасан актлах хөрөнгийг дансны бүртгэлээс хасч, үлдэх өртгийг алдагдалд тооцохыг Ерөнхий нягтлан бодогч /Г.Золжаргал/-д даалгасугай.
- 3. Тус хавсралтад заасан үндсэн хөрөнгөөс худалдах боломжтой хөрөнгийг худалдан борлуулж, орлогыг компанийн орлогод бүртгэхийг зөвшөөрсүгэй.
- 4. Энэхүү тогтоолын дагуу хөрөнгө актлах ажиллагааг зохион байгуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Удвал/-д үүрэг болгосугай.

R [199 Building and and have well лэндмн ббс ТУЗ-ИЙН ДАРРА: улаанбаатар/ОтБОЛДБААТАР/ 5039754 Ja 1118267206 A BRIDE STATE STATES

"ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ТӨЛ<u>Ө</u>ӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 23-ны өдөр

№ 21/45

Улаанбаатар хот

Эрсдэлийн удирдлагын бодлого шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, "ЛэндМН ББСБ" ХК-ийн дүрмийн 9.6.17 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны 2021 оны 12 дүгээр сарын 23 -ны өдрийн хурлаас гарсан дүгнэлтийг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

- 1. "ЛэндМН ББСБ" ХК-ийн Эрсдэлийн удирдлагын бодлогыг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
- 2. Эрсдэлийн удирдлагын шинэчилсэн бодлогыг хэрэгжүүлж ажиллах, гүйцэтгэлийг ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Б.Удвал/-д үүрэг болгосугай.
- 3. Эрсдэлийн удирдлагын бодлогыг шинэчлэн батлагдсантай холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, шаардлагатай өөрчлөлтийн саналыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Удвал/-д даалгасугай.
- 4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга /Б.Дэлгэржаргал/-д даалгасугай.

туз-ийн дарга: /О.БОЛДБААТАР/ улаанбаатар хот 5039754 3.1118267206

"ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 23-ны өдөр

№ 21/46

Улаанбаатар хот

Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлого шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, "ЛэндМН ББСБ" ХК-ийн дүрмийн 9.6.17 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны 2021 оны 12 дугаар сарын 23 -ны өдрийн хурлаас гарсан дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

- 1. "ЛэндМН ББСБ" ХК-ийн "Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах зарцуулах бодлого"-ыг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
- "Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлого"-ыг хэрэгжүүлж, түүнд нийцүүлэн холбогдох журам, заавар, загвар, аргачлалыг боловсруулан баталж, мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Удвал/-д үүрэг болгосугай.
- 3. "Зээл түүнтэй адилтгах активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлого"-ын хэрэгжилт, зээл, түүнтэй адилтгах активт байгуулсан эрсдэлээс хамгаалах сан, түүний зарцуулалтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Удвал/-д даалгасугай.
- 4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга /Б.Дэлгэржаргал/-д даалгасугай.

пандин ТУЗ-ИЙН ДАРГА: улаанбаатар хоолд Баатар/ 5039754 .4.1118267206